Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдл ын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтийг нийт зардлаар 502.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Бэлчээрийн менежмент төслийн зорилго нь Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах, тэжээлийн олон наст ургамлыг тарьж, чанар сайтан хадлан, тэжээл авахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг

тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах гэж тодорхойлжээ.

Нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах шинэ технологийг нэвтрүүлснээр бэлчээрийн талхагдлыг багасгаж, цөлжилтийг бууруулна.
- Тэжээлийн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг 2-3 дахин ихэсгэх боломж бүрдэнэ.
- Дээрх шинэ технологийн дагуу тариалсан олон найрлагат, ууржуулсан витаминт тэжээлийг вакумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр өвөл, хаврын улиралд ч шимт чанарыг алдагдуулахгүйгээр малаа тэжээх боломж бүрдэнэ.
- Туршилтын талбай, тэжээл, сүүний гарцын судалгаа болон сургалт, засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулна.
- Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах ба ингэснээр төслийн хүрээнд хийх “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй”-нд тулгуурлан практик байдлаар дээрхи дэвшилтэт технологиудыг танилцуулах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, бодитоор хэрэгжүүлэхэд нь туслах юм.
- Нэг монгол үнээнээс саалийн хугацаанд авах сүүний гарц 2000 л байдаг бол нэгж талбайгаас авах ногоон массын ургац болон тэжээлийн шимт чанарыг сайжруулснаар сүүний гарцыг 2 дахин нэмэгдүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Улсын Төсөвт Үйлдвэрийн Газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар эзэмшиж байна.

## 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 121 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

НЗД-ын 2017 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн А/282 тоот захирамжаар тус газрын бүтэц, орон тоог шинэчлэн 10 хүний орон тоотойгоор баталж, үйл ажиллагааг явуулж байна. Дахин өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн

оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг хэвээр хадгалж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог хэвээр хадгалж, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон хэдий ч тайлант хугацаанд 2 ажилтанд үр дүнгийн шагнал олгосон байна. Үүнд албан шаардлага хүргүүлэхээр боллоо.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг шалгахад

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон.

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангууд нь Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 852.8 сая төгрөгөөр буюу 86.4 хувиар өссөн байна. Энэ нь Нийслэлийн засаг даргын 2021 оны 5 сарын 31-ний Нийслэлийн өмчид барилга, байгууламж бүртгэн авах А/399 дүгээр захирамж, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны 6 сарын 2-ны 3/690 дүгээр Хөрөнгө бүртгэх тухай тушаалын дагуу 1,023,269.7 мянган төгрөгийн иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуйн барилга, байгууламжийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| БХХО | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 108,453.3 | 110,232.1 | 1,778.7 |
| Үндсэн хөрөнгө | 878,235.1 | 1,729,319.7 | 851,084.5 |
| Биет бус хөрөнгө | 4,113.1 | 2,117.6 | 1,995.5 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгийн дүн** | **986,688.5** | **1,839,551.8** | **852,863.2** |
| Өр төлбөрийн дүн | | | |
| Богино хугацаат өглөг | | | |
| Урт хугацаат өглөг | | | |
| Эздийн өмч | 986,688.5 | 1,839,551.8 | 852,863.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **986,688.5** | **1,839,551.8** | **852,863.2** |

Бараа материалын дансны үлдэгдэл 110 сая төгрөг болж өссөн байна. Үүнд; Мал амьтад оны эхэнд 30.8 сая төгрөг байсан 66.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 3.6 сая төгрөгийн мал амьтад устгалд оруулж, нийт 46.6 сая төгрөгийн мал амьтад хасагдаж 51.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нийт бараа материалын 46.6 хувийг эзлэж байна. Үлдсэн 53.4 хувь нь түүхий эд материал 1.0 сая, дуусаагүй үйлдвэрлэл 15.3 сая, аж ахуйн материал 5.3 сая, сэлбэг хэрэгсэл 1.9 сая, бусад хангамжийн материал 34.7 сая, бичиг хэргийн материал 0.6 сая буюу 110.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 5.9 сая төгрөгийн худалдан авалт хийж Бусад үндсэн хөрөнгө дансанд, Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогод Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2021 оны 05 сарын 31-ний өдрийн А/399 дугаар захирамж, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны 06 сарын 02-ны өдрийн 3/690 дугаартай албан тоотыг тус тус үндэслэн байгууллагын даргын 2021 оны 06 сарын 02-ны өдрийн А/105 тоот шийдвэрээр нийт 1,023.3 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч холбогдох дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

НБББББ (2018.12.31-нд батлан мөрдөж буй) нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой байгууллагын ерөнхий үйл ажиллагааны хүрээнд нийцэх ч үндсэн чиглэл болох биологийн хөрөнгө хүлээн зөвшөөрөлт, түүний өсөлт бууралт, хэмжилтийг хэрхэн бүртгэхтэй холбоотой тусгай бодлого бүрэн тусгагдаагүй байгаа нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо сайжруулан шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Акулус програм, цалингийн Пэйрол систем ашигладаг. Сул тал нь үйлдвэрлэлийн өртөг, зардлын бүртгэлтэй холбоотой журнал бичилтүүдийг хийх боломжгүй, үйлдвэрлэл хоорондын хөдөлгөөнийг стандарт бус бичилтээр хийгдэг. Шинэчлэлт тогтмол хийгддэггүй байна.

Бэлчээрийн менежмент төслийн нэгжийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 939.5 сая төгрөгөөр буюу 367.5 хувиар өссөн байна. Үүнийг ангилж харуулбал;

- *Татварын бус орлого 1,006.8 сая төгрөгөөр өссөн ( үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 1.023.3 сая төгрөгөөр өсч, үндсэн үйл ажиллагааны орлого 11.5 сая төгрөгөөр буурсан) байна.*
- *Тусламж санхүүжилтийн орлого 67.3 сая төгрөгөөр буурсан байна.*

Зардал өмнөх онтой харьцуулахад зардал 79.0 сая төгрөгөөр хасагдсан нь оны эхэнд байгууллагын статус өөрчлөхтэй холбоотойгоор цалингийн төсвөөс бусад төсөв батлагдахгүй үйл ажиллагаа явуулахад тодорхой хэмжээний бэрхшээл тохиолдсон ба оны дунд үеэс төсвийн санхүүжилтийг олгож эхэлсэнтэй холбоотой байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт дуусаагүй үйлдвэрлэлтэй холбоотой буюу үхрийн фермийн аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаанд тавьж олгосон зардлуудыг хамруулсан байна. Үүнээс 17.8 сая төгрөгийн өртөг хуваарилагдах зардлуудыг үйл ажиллагааны зардалд тусгасныг завсрын аудитаар залруулсан.

### 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус нэгжийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 261.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 258.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлуулсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төслийн нэгжийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 261.2 сая төгрөгийн төсөв баталснаас 258.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 256.5 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 1.7 сая төгрөг, нийт 258.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 257.7 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмжид олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 256.5 сая төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй

**Нэмэлт төсөв**

НЗДТГ-аас нийт 1.5 сая, 3.3 сая, нийт 4.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс, 3.3 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, зорилтот өрхийг сайжруулсан түлшээр хангахад 1.5 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулжээ.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 12,973.7 мянган төгрөгийн дүн бүхий таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, нэмэлт өөрчлөлтийн 1 дүгээр сарын мэдээ, байгууллагын батлагдсан төсөв, орон тоо, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн талаарх 11 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 6 удаагийн худалдан авалт зохион байгуулжээ.Үүнд: байрны түрээс, шатахууны төлбөр, авто машины түрээс, байрны төлбөр, гэрэл цахилгааны төлбөр, бусад бараа материалын төлбөр зэрэгт 74.6 сая төгрөгийн худалдан авалтын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 74.6 сая төгрөгийн худалдан авалт хийжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 6.1. Завсрын аудитын үр дүн:

Завсрын аудитаар 48,881.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 46,231.5 мянган төгрөгийг залруулж, 2,650.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 46,231.5 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 2,650.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### 6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс зөвлөмж жилийн эцсээр 100 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 4 | 3.7 | 4 | 3.7 | - | - | - |
| Нийт дүн | 4 | 3.7 | 4 | 3.7 | - | - | - |

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

НББББББ болон ашиглаж буй программ хангамжийг шинэчлэн, өртгийн төв бүрийн хувьд холбогдох дуусаагүй үйлдвэрлэлийн дансыг нээн бүртгэж буй эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 51,998.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 48,881.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,994.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,122.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3,116.9 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 5,648.8 мянган төгрөгийн түвшинээс 2,531.9 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 48,881.5 мянган төгрөгийн алдааг залруууллаа. Үүнд:

- Фермийн үйл ажиллагаанд зарцуулсан 16,045.8 мянган төгрөгийн малын тэжээл, тарьж ургуулахад зориулж талбайд цацсан 1,774.0 мянган төгрөгийн овьёосны үрийг үйл ажиллагааны зардалд суулгасан. Энэ нь УСНББОУС12 (Бараа материал)-ын 20 дугаар зүйл, НББОУС-2 (Бараа материал)-ын 12 дугаар зүйлийн "*Бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлуудаас бүрддэг... мөн материалыг бүтээгдэхүүн болгон хувиргахад гардаг үйлдвэрлэлийн тогтмол ба хувьсах нэмэгдэл зардлын системчилсэн хуваарилалт нь энд хамаардаг*" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "*үнэн зөв байх, оршин байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Машин тоног төхөөрөмж дансанд тусгагдсан 22,416.7 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшлыг тусгасан, тайлант хугацаанд 5,995.0 мянган төгрөгийн хашаанд элэгдэл тооцоолоогүй, түүнчлэн 2,650.0 мянган

төгрөгийн өртөг бүхий компьютерийн ашиглах хугацааг буруу тооцсон нь УСНББОУС17 (Үндсэн хөрөнгө)-гийн 76 зүйлд “Хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол нь ижил төсөөтэй хөрөнгүүдийн талаарх уг байгууллагын туршлагад үндэслэсэн шүүн тунгаалтын асуудал” гэсэнтэй, санхүүгийн тайлангийн үнэлгээ, хуваарилалт батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй;

### 8.3 Албан шаардлага

Тайлант онд Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтийг шалгахтай холбоотойгоор дараах зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

Төслийн нэгж нь байгууллагын үр дүнг тооцон 2 ажилтныг нийт 1,994.2 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан. Үүнд: Байгууллагын нягтлан бодогч Ц.Мөнхдөлийг 797.6 мянган төгрөгөөр, ерөнхий менежер н.Пүрэвсүрэнг 1,196.5 мянган төгрөгөөр тус тус шагнасан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “*Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх*” гэж заасантай нийцээгүй, мөн “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Дуусаагүй үйлдвэрлэлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд фермийн үйл ажиллагаанд ашигласан 372.7 мянган төгрөгийн малын тэжээл болох ашигт долооц, 750.0 мянган төгрөгийн өртөг бүхий компас бордоо зэрэг нийт 1,122.7 мянган төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэлд тавьж олгосон зүйлсийг байгууллагын үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх үнэн зөв байх гэсэн заалтыг зөрчсөн байна. Түүнчлэн УСНББОУС12 (Бараа материал)-ын 20 дугаар зүйл, НББОУС2 (Бараа материал)-ын 12 дугаар зүйлийн “Бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлуудаас бүрддэг... мөн материалыг бүтээгдэхүүн болгон хувиргахад гардаг үйлдвэрлэлийн тогтмол ба хувьсах нэмэгдэл зардлын системчилсэн хуваарилалт нь энд хамаардаг” гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Байгууллагын үйл ажиллагааны зардалд тусгасан дээрх гүйлгээг мал аж ахуйтай холбоотой гарсан малын тэжээлийг фермийн үхрийн нас дэвшилт, төл мал болон сүүний өртөг зэрэгт шингээх зорилгоор, холбогдох дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд хуримтлуулан, газар тариалан болон олон наст ургамал ургахтай холбоотой гарсан үр, бордооны зүйлсийг олон наст ургамал, ногоон тэжээл зэргийн өртөгт шингээх зорилгоор холбогдох дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд тус тус хуримтлуулан бүртгэж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ | ХАК-2022/10/НА-СА-ОНА | Фермийн үйл ажиллагаанд зарцуулсан 372.7 мянган төгрөгийн малын тэжээл, 750.0 мянган төгрөгийн компас бордоог үйл ажиллагааны зардлаар бүртгэсэн. | Үйлдвэрлэлтэй холбоотой зардлыг дуусаагүй үйлдвэрийн зардалд хуваарилах; | 1 | 1,122.7 | | | | | | | | | 1 | 1,122.7 |
| 2 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ | ХАК-2022/10/НА-СА-ОНА | Тайлант хугацаанд 16,045.8 мянган төгрөгийн малын тэжээл, 1,774.0 мянган төгрөгийн овъёосны үрийг үйл ажиллагааны зардалд тусгасан. | Холбогдох үйлдвэрлэлийн өртөгт тусгах; | 1 | 17,819.8 | 1 | 17,819.8 | | | | | | | | |
| 3 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ | ХАК-2022/10/НА-СА-ОНА | 22,416.7 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшлыг буруу дансанд бүртгэсэн. 5,995.0 мянган төгрөгийн өртөг бүхий хашаанд элэгдэл тооцоогүй. 2,650.0 мянган төгрөгийн компьютерын ашиглах хугацааг буруу тооцож элэгдэл байгуулсан. | Хөрөнгийн холбогдох данс бүртгэлд тусгах, элэгдлийг нөхөн байгуулах, ашиглах хугацааг өөрчлөх; | 1 | 31,061.7 | 1 | 31,061.7 | | | | | | | | |
| | Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ | ХАК-2022/10/НА-СА-ОНА | Байгууллагын үр дүнг тооцон төслийн нэгжийн 2 ажилтныг нийт 1,994.2 мянган төгрөгөөр шагнасан. | ЗГ-ын 43 дугаар тогтоолын 1.3-г мөрдөх, | 1 | 1,994.2 | | | | | 1 | 1,994.2 | | | | |
| **ДҮН** | | | | | **4** | **51,998.4** | **2** | **48,881.5** | | | **1** | **1,994.2** | | | **1** | **1,122.7** |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Бэлчээрийн менежмент төслийн нэгж УТҮГ | ХАК-2022/10/НА-СА-ОНА | Шилэн дансны нэгдсэн системд 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | Шилэн дансны тухай зүйлийн 6-г мөрдөн ажиллах; | 1 | 12,973.7 | | | | | | | | | 1 | 12,973.7 |
| | **ДҮН** | | | | **1** | **12,973.7** | | | | | | | | | **1** | **12,973.7** |
| **НИЙТ ДҮН** | | | | | **5** | **64,972.1** | **2** | **48,881.5** | | | **1** | **1,994.2** | | | **2** | **14,096.4** |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР Л.ГАНЗОРИГ

**ХЯНАСАН:**

“НИЙСЛЭЛ АУДИТ” ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Т.СУГАРСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ НИЙСЛЭЛ АУДИТ ХХК ТТГ4872 рд 5009766

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.03.15 № 634

танай ____________-ны №____________-т

"БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ
ТӨСЛИЙН НЭГЖ" УТҮГ-ЫН ДАРГА
Н.УУГАНБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 1,994.2 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002030840

D:\Desktop\2022\Word\Явсан бичиг\2022.03.15.Belcheeriin.managment.ash.A5.docx

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 сарын 15 өдөр Дугаар 278/14025238 Улаанбаатар хот

ХТП-2022/10/ПА-СА-ОПП

## Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Байгууллагын зарим ажилтанд нийт 1,994,200.00 (нэг сая есөн зуун ерэн мянга хоёр зуун) төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна. Энэ нь Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3. "*Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, ..., цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх*" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11. *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал."*-д заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засгийн газрын "2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" УТҮГ-ын дарга Н.Уганбаяр, нягтлан бодогч Ц.Мөнхдөл нарт даалгав.

002041085

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН[1]:

“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Т.СУГАРСҮРЭН

АУДИТОР Л.ГАНЗОРИГ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦОГБАЯР

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар